



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/04 дүгээр тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

**УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ 83.6 ХУВЬТАЙ БАЙНА.**

Аудитын тайланг хүргүүлсэн: Дархан-Уул аймгийн ИТХ, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:



ДАРХАН-УУЛ АЙМАГ

2023 оны 04 дүгээр сар

Аудитын зорилго, зорилтууд:

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий дараах байгууллагууд хамрагдсан.

- Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-Төсвийн тухай хууль холбогдох журамд заасны дагуу төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах харилцааг зохицуулах чиг үүрэгтэй
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах ОНӨГ-ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиг үүрэгтэй
- “ДХББЗГ” ОНӨААТҮГ – Хуулийн дагуу захиалагч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу хяналтын үүргийг гүйцэтгэх чиг үүрэгтэй
- Тендерт шалгарч, ажил гүйцэтгэсэн 29 гүйцэтгэгч байгууллага хамрагдсан болно.

БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН ТАХ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ УЯЛДСАН БАЙНА.

Төсөл арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөжээ.

Аймгийн Засаг даргад эрх нь шилжсэн 44 ТАХ нь “Алсын хараас 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийг 2022 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдаж нийцсэн байна. Тухайлбал: “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Орон нутгийн чанартай авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг үе шаттай хэрэгжүүлэх зорилт, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2-т “*Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна*” гэж заасны дагуу Шарын гол, Хонгор сумын Салхит багт дэд бүтэц, дулаан дамжуулах сүлжээний өргөтгөлийн ажилд төлөвлөсөн байна.

ТАХ-ний 73.1 хувь нь салбар яамдын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдсан байна.

Аудитаар эрх шилжсэн нийт 96,109.3 сая төгрөгийн ТАХ-нээс хамгийн их хувийг эзлэх ЗТЯ-ны 4, БШУЯ-ны 10 ажлыг салбарын бодлого, орон нутгийн хөгжлийн бодлогод нийцсэн байдлыг тулгахад бодлого, төлөвлөлттэй уялдсан байна.

Хөрөнгө оруулалтын бүс шинж чанартай ТАХ-г төлөвлөөгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр эрх шилжиж ирсэн нийт төсөл, арга хэмжээний 88.7 хувийг барилга байгууламж, 9.4 хувийг их засвар, 2.0 хувийг тоног төхөөрөмж худалдан авах ажилд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г орон нутгийн хэрэгцээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор эрэмбэлсэн байна.

Аймгийн ТЕЗ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 62 ТАХ-г орон нутаг, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлж холбогдох яамдад хүргүүлсэн байна.

Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний зураг төсвийг хууль батлагдсаны дараа боловсруулж, баталгаажуулдаг зөрчил арилаагүй байна.

Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр 14 ТАХ-ний зураг төсөвт Барилгын тухай хуулийн 25 дугаар заалтын дагуу магадлал хийлгэж баталгаажуулсан хэдий ч 4 ТАХ-ний магадлал төсөв батлагдсанаас хойш хийгдсэн.

Мөн эрх шилжсэн ТАХ-ний төсөвт магадлал хийсэн дүнгээс өөр өртгөөр тусгаж, зөрүү үүссэн нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тухайлбал: Барилга байгууламжийн төсөвт өртөг магадлалаар баталгаажсан дүнгээс нийт 6 ТАХ зөрүүтэй батлагдсан байна.

БҮЛЭГ Б. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХОЛБОГДОХ ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЖЭЭ.

Гэрээ шууд байгуулах арга хэрэглэсэн ТАХ-ний үр дүнг худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлээгүй байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 32, харьцуулалтын аргаар 1, нийт 33 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламж, их засвар, замын ажил зэрэг нийт ТАХ-ний 77.0 хувьд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 4 дүгээр сараас хойш буюу барилгын улирал эхэлснээс хойш зохион байгуулсан.

Шарын гол сумын Дархан баг чиглэлийн дулааны шугамын өргөтгөл, Анагаах ухааны сургуулийн спорт заалны гүйцэтгэгчээр шалгарсан “Тоосгон-Уул” ХХК, “Эй уан констракшн дизайн” ХХК-ууд нь материалын үнийн өсөлт, тайлант оны санхүүжилтийн дүн буурсан зэргээс шалтгаалан гэрээ байгуулахаас татгалзсан бөгөөд захиалагч ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34.1.1¹-т заасан гэрээ шууд байгуулах аргаар “Цахир түмэн алтай” ХХК, “Элчит ган” ХХК-уудтай гэрээ байгуулсан ч өөрчлөгдсөн гэрээний хувийг Сангийн яаманд хүргүүлээгүй, үр дүнг худалдан авах ажиллагааны цахим системд байршуулаагүй байсан.

Зарим барилга байгууламжийн дотоод заслын ажил чанаргүй хийгдсэн байна.

Тайлант онд шилжих хөрөнгө оруулалтаар 51,010.2 сая төгрөгийн 14, шинээр хэрэгжих 7,132.9 сая төгрөгийн 15, нийт 58,143.1 сая төгрөгийн 29 барилга, байгууламж барих, өргөтгөх ажил төлөвлөснөөс гүйцэтгэлээр 29 ажилд 46,772.6 сая төгрөг зарцуулсан. Төлөвлөсөн ажлаас 50 хувийн гүйцэтгэлтэй 1, хугацаандаа хэрэгжээгүй 4, хэрэгжээгүй 1 ТАХ байна. Үүнд:

- Шарын гол сумын “Хуучин хөл бөмбөгийн талбайг түшиглэн орчин үеийн хөл бөмбөгийн талбай байгуулах” ажлын тухайн онд санхүүжих дүнг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн Төсвийн тухай хуулиар 1,040.0 сая төгрөгөөр бууруулан баталснаас 50 хувийн гүйцэтгэлтэй, ажил гүйцэтгэх гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 01 хүртэл сунгасан,
- Гүйцэтгэгч байгууллагаас шалтгаалж “Дархан сумын 4 дүгээр сургуулийн барилгын ажил”-ыг гэрээнд зааснаас 10 хоногоор, “Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн хөл бөмбөгийн иж бүрэн талбай, тохижилтын ажил”-ыг гэрээнд зааснаас 126 хоногоор,

¹ Энэ хуулийн 30.4.3, 36.18-д заасан тохиолдолд

“Хуучин дарханы спортын ордны барилгын ажил”-ыг гэрээнд зааснаас 10 хоногоор тус тус хугацаа хэтрүүлсэн,

- Музей, номын сангийн цогцолборын барилгын ажлыг гүйцэтгэгч “Воком констракшн” ХХК нь барилга угсралтын явцад технологийн алдаа гаргаж, гэрээнд заасан хугацаанд ажлыг бүрэн дуусгаагүй байна.
- Орхон сумын төвийн доторх авто замын их засварын ажил зураг, төсөв алдаатай хийгдсэнээс хэрэгжээгүй байна.

Дээрх зөрчилд чанаргүй хийгдсэн дотоод заслын ажлуудыг гэрээний баталгаат хугацаанд дахин хийлгэж, засварлуулах албан шаардлагыг “ДХББЗГ” ОНӨААТҮГ-ын удирдах албан тушаалтанд хүргүүлсэн.

Тайлант онд төлөвлөсөн ажлаас хугацаандаа хэрэгжээгүй, гүйцэтгэл нь дутуу зэргээс шалтгаалан төлөвлөгөөний биелэлт 80.4 хувьтай байна.

Гүйцэтгэгч байгууллагууд 18,956.6 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч санхүүжилтийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9²-т заасны дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй, ХБТХОХ нь захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний 2.3³, 3.2⁴-т заасныг хэрэгжүүлээгүй, гэрээний үүргийг биелүүлээгүй байна.

Дархан-Уул аймагт төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн 44 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 50,263.6 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон байна

Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллага үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн боловч барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг тухай бүр хөтлөөгүй байна

Аудитаар нийт 38 ТАХ-нээс түүвэрлэн 9 ТАХ-ний хэрэгжилтэд захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн байдлыг тулгахад “барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл”-д бүрэн хөтлөгдөөгүй, хяналтаар өгсөн зөвлөмж, шаардлагын хэрэгжилтийн тэмдэглэл хөтөлж баталгаажуулдаггүй алдаа, зөрчил давтагдаж байна.

ТАХ-г хүлээн авах комисс нь өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэж, холбогдох хууль дүрмийн дагуу дүгнэлт гаргаж хүлээн авсан байна.

Аймгийн Засаг дарга авто замыг ашиглалтад оруулах комиссыг 2019 оны 01-А/29, барилга байгууламж ашиглалтад оруулах болон авто тээврийн хэрэгсэл, тавилга, техник хэрэгсэл, компьютер, багаж тоног төхөөрөмж хүлээн авах комиссыг 2021 оны 01-А/338 дугаар захирамжаар тус тус байгуулсан байна. Тайлант онд өмнөх оноос шилжиж ирсэн 32,286.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ, шинээр 3,813.7 сая төгрөгийн 2 ТАХ хэрэгжиж дууссан байна.

Ашиглалтад хүлээн авсан ТАХ-г бүртгэлд бүрэн тусгаж, зориулалтын дагуу хүлээн авсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжсэн 36,100.4 сая төгрөгийн 15 ТАХ-ээс 12 төсөл арга хэмжээг тайлант онд холбогдох газрууд бүртгэлд тусгасан бол 2023 онд 2 төсөл арга хэмжээг бүртгэж 1 төсөл арга хэмжээг бүртгэлд тусгах дээд газрын шийдвэр ирээгүй байна. Үүнд: Хуучин “Дархан спортын ордон”-ыг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 33/2022-д дугаартай комиссын акт, 480 суудалтай сургуулийн барилгыг 2022 оны 11

² Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно.

³ Гүйцэтгэгч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтын дагуу Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд санхүүжилт авсан тухай мэдээлэл байршуулаагүй нь дараагийн санхүүжилт олгохоос татгалзах эрхтэй.

⁴ Гүйцэтгэгч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтын дагуу 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр хэрэгжсэн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тухай бүр байрлуулах үүрэгтэй

дүгээр сарын 28-ны өдөр 31/2022-д дугаартай актаар хүлээн авсан боловч бүртгэлд авах иргэдийн хурлын тогтоол 2023 онд гарч бүртгэлд авсан байна. “Дархан дулааны сүлжээ” ТӨХК-ийн бүртгэлд тусгах 1,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тосгон чиглэлийн гадна дулааны шугамын ажлыг бүртгэлд тусгуулах саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн байна.

БҮЛЭГ В. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ 87 ХУВЬТАЙ ХИЙГДСЭН БАЙНА.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх ТАХ-ний санал нь Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Дархан хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг ханган биелүүлэхэд чиглэгдсэн байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Дархан-Уул аймгийн ТЭЗ тайлант онд 15,215.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 46 ТАХ-г хэрэгжүүлэх ХАА-ны төлөвлөгөөг Сангийн сайдын 2021 оны 102 тоот тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.9.1⁵-т заасны дагуу Сангийн яаманд цахим системээр баталгаажуулж, илгээсэн байна.

Аудитад ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан ТАХ-ээс нээлттэй тендер шалгаруулалтаар 37, харьцуулалтын аргаар 9, нийт 46 ТАХ-г хамруулав.

Үнэлгээний хорооноос захиалагчид гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхийг санал болгосон 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг үнэлээгүй, тендерийн урилга, үр дүнг худалдан авах ажиллагааны цахим системд байршуулаагүй буюу уламжлалт аргаар зохион байгуулж, гэрээ байгуулсан тухай бүр архивын нэгжийг бүрдүүлж, хадгалаагүй зэрэг зөрчил илэрсэн. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4⁶, 52 дугаар зүйлийн 52.1.12⁷, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалын 3.1⁸, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 6-1/6076 тоот зөвлөмжийн 6⁹, 16¹⁰, 18¹¹-д заасныг тус тус нийцээгүй байна.

Чанарын баталгаат хугацаанд эвдрэл гэмтэл үүссэн байна.

⁵ Улсын болон орон нутгийн төсөв батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор

⁶ Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан цахим хуудсанд байршуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээнэ.

⁷ Худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх зорилготой цахим хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох

⁸ Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг энэ журмын дагуу зохион байгуулна.

⁹ Захиалагч 20 сая төгрөг, түүнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргаар худалдан авах бол хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын дагуу тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүнг худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д нийтэлнэ.

¹⁰ Захиалагч хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангах аль болох олон аж ахуй эрхлэгчийг гэрээ шууд байгуулах ажиллагаанд оролцохыг урина.

¹¹ Захиалагч хуулийн 34 дүгээр зүйлийн дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдол бүрд архивын нэгжийг хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2 дахь хэсэгт зааснаар бүрдүүлж, хадгална.

Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх 165 төсөл, арга хэмжээнээс 144 нь гэрээт хугацаандаа, 8 нь огт хэрэгжээгүй бол 13 төсөл, арга хэмжээ гэрээ сунгагдан он дамжин хийгдэхээр болсон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх нийт 165 төсөл, арга хэмжээ нь нийт 34,104.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд гэрээний дүн 23,889.9 сая, санхүүжүүлэх дүн 21,189.4 сая төгрөг байна. Эдгээр төсөл арга хэмжээнд нийт 14,941.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 102 төсөл, арга хэмжээнд 12,047.4 сая, өмнөх онд хэрэгжүүлсэн 55 төсөл, арга хэмжээнд 2,894.0 сая төгрөгийг тус тус олгосон бөгөөд огт хэрэгжээгүй 8 төсөл байсан

Цаашид тухайн онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж байх шаардлагатай байна.

Аудитаар чанарын баталгаат хугацаанд эвдрэл гарсан дараах ажлууд байна. Үүнд:

- Цахим бар инженеринг” ХХК-ийн гүйцэтгэсэн 853.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1.4 км явган хүний замын газар доорх цэвэр, бохир усны шугам хагарсны улмаас 6.1 сая төгрөгийн 10 метр урттай зам эвдэрсэн,
- Өнөр зам” ХХК-ийн 88.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн гадна хашаанаас-хөшөө хүртэлх замд хагарал үүсч, доошоо хотойлт өгсөн,
- Дархан АЗЗА” ТӨХК-ний 96.6 сая төгрөгөөр гүйцэтгэсэн Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн дугуй барилгаас- хөшөө хүртэлх замд хагарал үүссэн,

Мөн “БЗД” ХХК-ийн 24.8 сая төгрөгөөр гүйцэтгэсэн “Од” цогцолбор сургуулийн биеийн тамирын хувцас солих өрөөний хаалга эвдэрсэн, хананы шавар унасан, 26.5 сая төгрөгөөр гүйцэтгэсэн 16 дугаар сургуулийн ариун цэврийн өрөөний сантехникийн засварын ажил чанаргүй хийгдсэнээс ус алдагдах нөхцөл байдал бий болсон зэрэг ажлуудыг гүйцэтгэлийн гэрээнд заасны дагуу чанарын баталгаат хугацаанд засуулах албан шаардлага хүргүүлсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажил 87 хувьтай хийгдсэн байна.

Бүрэн хэрэгжсэн ТАХ-ний санхүүжилтийг хугацаанд нь олгосон байна

Аудитаар төсөл арга хэмжээний гүйцэтгэлд олгосон санхүүжилтийг харилцах дансны дүнтэй тулган шалгахад тохирч байсан

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх нийт 165 төсөл, арга хэмжээ нь нийт 34,104.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд гэрээний дүн 23,889.9 сая, санхүүжүүлэх дүн 21,189.4 сая төгрөг байна. Эдгээр төсөл арга хэмжээнд нийт 14,941.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 102 төсөл, арга хэмжээнд 12,047.4 сая, өмнөх онд хэрэгжүүлсэн 55 төсөл, арга хэмжээнд 2,894.0 сая төгрөгийг тус тус олгосон бөгөөд огт хэрэгжээгүй 8 төсөл байна.

Захиалагчийн хяналтын зардалд 116.6 сая, зураг төсөл, зохиогчийн хяналтын зардалд 268.6 сая төгрөгийг тус тус гэрээний дагуу олгосон байна.

Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 01-А/29 тоот “Авто замыг ашиглалтад оруулах комисс томилох”, 2021 оны 01-А/338 тоот “Барилга байгууламж ашиглалтад оруулах комисс томилох”, 01-А/338 тоот “Авто тээврийн хэрэгсэл, тавилга, техник хэрэгсэл, компьютер, багаж тоног төхөөрөмж хүлээн авах комисс томилох” захирамжийн дагуу ажил хүлээн авах комиссын гишүүдийг томилон ажиллуулсан байна.

Бүрэн хэрэгжсэн ТАХ-г хүлээн авах комиссын гишүүд ажил хүлээлцэх гишүүний саналын хуудас, хурлын протоколыг үйлдэж ажлын гүйцэтгэлийг дүгнэн, шийдвэр гаргаж, ажил хүлээлцсэн актыг үйлдэн баталгаажуулж ирсэн байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Шинээр хэрэгжүүлэх ТАХ-г хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан хэдий ч зарим ТАХ-ний зураг төсвийг хууль батлагдсаны дараа боловсруулж батлуулсан байна.
- Гэрээ шууд байгуулах арга хэрэглэсэн ТАХ-г худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулаагүй, үр дүнг мэдээлээгүй байна.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажил 83.6 хувьтай хэрэгжсэн байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.
- Зарим барилга байгууламжийн дотоод заслын ажил чанаргүй хийгдсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Засаг дарга Б.Азжаргалд зөвлөж байна:

1. Тухайн онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж байх
2. Гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй гүйцэтгэгчид гэрээний ерөнхий нөхцөлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх
3. Гэрээний 2.3, 3.2-т заасны дагуу гүйцэтгэгч байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
4. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.4, 34 дугаар зүйлийн 34.3, 52 дугаар зүйлийн 52.1.12, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалын 3.1, 8.5-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан төсөл, арга хэмжээний урилга, үр дүнг худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах
5. Шууд гэрээ байгуулах арга хэрэглэсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан тухай бүр архивын нэгжийг бүрдүүлж, хадгалах,

Аудитаар нийт 25,321.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийлгэх 963.9 сая төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлэн, цаашид үйл ажиллагаанд мөрдөж ажиллах 24,357.2 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.